




ЛАМ НАРЫН


2010 он, 12 сар №4

СЭТГҮҮЛ



МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛ БА БОГД ЭЗЭН ХААН

**ТУСГААР ТОГТНОЛОО СЭРГЭЭХИЙН ТӨЛӨӨ ХИЙСЭН
ТЭМЦЛИЙН ТҮҮХИЙГ ШИНЭ, ЗӨВ БАЙР СУУРИНААС
ЭРГЭЖ СУДЛАХ ШААРДЛАГА**



Телеки Кристина

Нийслэл хүрээнд байсан сүм хийдүүд

Нийслэл хүрээ нь XX зууны эхэн үеийн Богд хаант Монгол улсын нийслэл одоогийн Улаанбаатар хот бөгөөд олон удаа нүүдэллэсэн нийслэл юм. Анх 1639 онд Түшээт хан Гомбодоржийн хүү Өндөр гэгээн Занабазарыг анхдугаар богдод өргөмжилж одоогийн Өвөрхангай аймгийн нутаг Бүрд хэмээх газарт Монгол улсын нийслэлийн анхны шавыг Өргөө хэмээн нэрлэжээ.

1778 онд 26 нүүсний эцэст Сэлбэ гол, Туул голын дундах Алтан тэвшийн хөндийд суурьшсан хэдий ч 1839 онд Толгойт руу нүүж, 1855 онд буцаж ирэн түүнээс хойш энэ хөндийд суурьшсан түүхтэй. Нийслэл хүрээ нь энэ цаг үеэс эхлэн монгол орны гол засаг захиргаа, эдийн засаг, худалдаа арилжаа, шашны томоохон төв болон хөгжсөн. Нийслэл хүрээ нь 10 дацан, 30 аймагтай 10000 гэлэнгийн хайлан хайлдаг хамгийн том хүрээ байлаа.

XX зууны эхний хагаст Монгол оронд олон үйл явц тохиосны нэг нь шашны хөгжилд томоохон хар толбо болон үлдсэн билээ. Үүний дотор монгол уран дархчуудын хэдэн зуун жил хийж бүтээсэн сүм хийдүүдийг устгасан явдал юм.

Хүрээнд их хэлмэгдүүлэлт болох хүртэл байсан 50 орчим хийд, 100 шахам сүм дугануудын нарийн гаргасан жагсаалт өдий хүртэл гаргаагүй байна. Энэ

өгүүлэлд хүрээний хөгжил, үүх түүх, хороонуудад байсан сүм хийдүүдийн тухай баримт түшиглэн товчхон танилцуулна.¹

Сурвалжууд

Б. Ринченгийн угсаатны зүйн атласын 31 дүгээр зураг “Хүрээ, хийд Улаанбаатар хот” хэмээх бүтээлд нийслэл хотод байсан 32 шашны холбогдол бүхий газрууд (ордон, сүм хийд, хурал)-ыг тэмдэглэсэн (цаашид Р 910-941)². Тус жагсаалтанд 19 газар шинээр нэмсэн болно (цаашид НР 942-960). Энэ 51 газрын зарим нь ганц дугантай, зарим нь олон дугантай ч байлаа. Нийслэл хүрээний хамгийн алдартай зураг бол 1913 онд VIII Богдын зарлигаар Жүгдэрийн зурсан зураг одоо Богд хааны ордонд хадгалагдаж байна. Үүнээс гадна Улаанбаатар хотын музей, Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Үндэсний номын сан зэрэг газруудаас ч мөн үзэж болно. Хүрээний гэрэл зургуудын ихэнх нь Улаанбаатарын Кино Архивд хадгалагдаж байна. (21, 92, 93, 95, 96, 163 дугаартай хайрцагуудад тус тус хадгалагдаж байна.) Мөн судлаач, жуулчид, урлаг судлалын бүтээлүүдээс олж харж болно.³

XIX зууны эцсээр гарсан сурвалж бичгүүдийн нэг бол тухайн үеийн шашны өдөр тутмын үйл ажиллагааг дэлгэрэнгүй бичсэн Позднесвийн бүтээлүүд зүй ёсоор

орно.⁴ Төвд судлаач нарын бүтээлүүдээс дурдвал: Ш.Бира, Гомбожав, Huth, Lokesh Chandra, Бүрнээ-Энхтөр⁵ болон монгол судлаач Позднеев, Bawden⁶, эдгээрээс гадна Улаанбаатарт байгаа архивуудад (Үндэсний Төв Архив, МАХН-ын архив, Тагнуулын Ерөнхий Газар) сурвалжууд нилээд бий. Үүний талаар С.Пүрэвжав, О.Пүрэв, Ө.Сэрээтэр нар хамгийн сайн судалжээ.⁷ Мөн хүрээнд шавилан сууж байсан лам нараас тэмдэглэж авсан баримтууд: Ц.Дамдинсүрэн, Bawden, Д.Наваан⁸. Хүрээнд шавилан сууж байсан одоо ч амьд сэрүүн байгаа лам нар: Гончиг, Дашчойнпэл дацан), Лувсан (Гандан хийд), Дашцэрэн (Пунцоглин хийд), Дагва (Манба дацан), Лхамсүрэн (Зүүн хүрээ Дашчойлин хийд), Дашням (Ламрим дацан), Цэрэнпунцаг (Дашчойнхорлин хийд, Зуунмод).⁹

Улаанбаатар хотын түүхээс

XVII зуунаас эхлээд Монгол оронд Төвдөөс буддын шашин хүчтэй дэлгэрсэн. Энэ үеэс эхлэн сүм дуган, хүрээ хийдүүд олноор баригдаж эхэлсэн байдаг. Үүн дотроос одоогийн нийслэл хотын түүх ч энэ үеэс л үүсэлтэй билээ. Анх 1639 онд сууриа тавьснаас хойш 1706 он хүртэл Өргөө хэмээх нэрээрээ нэрлэгдэж байлаа. Харин 1706-1778 он хүртэл Их хүрээ, 1778-1911 он хүртэл Да хүрээ зарим үед Хүрээ гэж дууддаг байжээ.¹⁰ 1911-1924 он хүртэл Нийслэл хүрээ, 1924 онд одоогийн нэрээр нэрлэгдэх болсон байна. Ард түмний дунд нийслэл хотыг Ардын хувьсгалаас өмнө их олон янзаар нэрлэж байжээ. Жишээ нь:

Богдын хүрээ, Хутагтын хүрээ, Хүрээ, Номын хүрээ гэх мэт.

Гадаадын судлаачдын зохиол бүтээлд тэр дундаа европын орнуудад Урга (Өргөө) нэрээр нэрлэсэн байдаг.

Хүрээний үүсгэл ба нүүдэл, Богдуудын хүрээ хөгжүүлсэн үйл ажиллагаа.

Анхдугаар Богд Лувсандамбийжалцан буюу Өндөр гэгээн Занабазар (1635-1723)-т зориулан орд өргөө Ширээт цагаан нуур (Өвөрхангай, Бүрд сум)-т байгуулсны хойно Хөшөө цайдам (1640)-д нүүн ирсэн байна. 1651 онд Төвдөөс Занабазар буцаж ирээд өргөөгөө дахин шинээр зохион байгуулж түүнтэй хамт сууж байсан хүмүүс долоон аймагт суусан (Позднеев., 1971, 44-46). Тус долоон аймаг нь голдуу үйл ажиллагааны чиглэлээрээ нэрээ авсан. Сангийн аймаг (Сангайн аймаг), Зоогийн аймаг (Зоогийн аймаг), Жасын аймаг (төв. sruisa, аж ахуй), Дархан эмчийн аймаг, Андуу нарын аймаг (Төвдийн Амдо мужаас ирсэн буюу Төвдөөс ирсэн хүмүүс (лам нар)), Өрлөгүүдийн аймаг (Өрлүүд аймаг ч гэнэ), Хүүхэн ноёны аймаг. Өндөр гэгээн 1654 онд Хэнтийд орд өргөөгөө нүүлгэж анхны цогчин дуганг байгуулсан. Төвөө Шар ордон буюу Богдын шар бүсийн өргөө гэж нэрлэж байлаа. Өргөөг дараа нь (О.Пүрэв “Хүрээний нүүдлийн тухай” 1999, 12) Өгөөмөр (1688), Өвөр Монгол (1690), Цэцэрлэгийн Эрдэнэтолгой (1700), Дааган дэл (1719), Усан сээр (1720), Их тамир (1722), Жаргалант (1723). Өндөр гэгээнийг насан өндөр болох үед Өргөөний аймгууд 11 болон өргөжсөн байлаа. Үүнд:

Шүтээний аймаг, Сэцэн тойны аймаг, Баргын аймаг, Бандидын (санс. paupita) аймгууд бий болсон. (Сэрээтэр, 1999, 9.)

Энэ үед Өргөөг Их хүрээ хэмээн нэрлэх болжээ.

1724 онд Их хүрээ Ивээн голын Угтаал Жаргалант нүүн ирсэн байна. II богд Лувсандамбийдонмэ (төв. blo-bzang bstan-pa'i sgron-me, 1724-1758)-гийн үед Угтаал Жаргалантаас Хужиртбулан (1729), Бургалтай (1730), Сөгнөгөр (1732), Тэрэлж (1733), Улиастай (1734), Хүй Мандал (1736). Зава лам Дамдингийн “Алтан дэвтэр”-г тэмдэглэсэнээр (98г-99в) II богд 1739 онд Их хүрээнд Дэчинсанаглин (төв. bde-chen gsang-sngags gling) нэртэй жүд (төв. rgyud)-ийн хурлыг байгуулсан. Их хүрээ дахин Хүй Мандалаас Хунцал (1740), Үдлэг (1742), Өгөөмөр (1743), Сэлбэ (1747), Улиастай (1756 онд эргэн ирсэн).

1756 онд анхны “Цанид” (төв. mtshan-nyid) хэмээх шашны сургууль байгуулагдсан. Тус сургууль нь Төвдийн Бэрэйвэн хийдийн Гоман (төв. sgo-mang) дацангийн гүн ухааны жишгээр сургалтаа явуулж байлаа (Гүнчин игчаа). II богдын үед шинээр 11 аймгийг үүсгэсэн. Үүнд:

Эрхэм тойн, Мэргэн номун хан, Вангийн аймаг, Номч, Мэргэн хамба, Эрдэнэ хувилгаан, Жадар (төв. kye-rdor), Лам нар, Бизьяа (санс. Ueyueavijayā), Дугар (төв. gdugs-dkar), Дүйнхор (төв. dus-'khor)-ийн зэрэг аймгууд болон Богдын шавь нарын хэргийг удирдах Эрдэнэ шанздавын яам (төв. phyag-mdzod-pa) буюу Сангийн яам бий болсон.

III богд Ишдамбийням (төв. ye-shes bstan-pa' nyi-ma, 1758-1773) 1760 онд Их хүрээнд Эмчийн дацан (Эрдэнэ эмч, Манба дацан, төв. sman-pa grwa-tshang) байгуулсан (“Алтан дэвтэр”, 99а). Улиастайгаас дахин Сэлбэ (1762), Хүй Мандал (1772) эргэн нүүж ирсэн. Их хүрээнд монгол, манж амбан томилогдсон.

IV богд Лувсантүвдэнванчигжигмэджамц (төв. blo-bzang thub-bstan dbang-phyug 'jigs-med rgya-mtsho, 1775-1813)-ийн үед 1778 онд Их хүрээ Хүй Мандалаас буцаж Сэлбэ голын эрэгт ирж, 1789 онд зурхайн дацан (төв. rt-sis-pa grwa-tshang) байгуулагдсан (“Алтан дэвтэр” 101v-106v). 1806 онд Дэчингалавын сүм (төв. bde-chen bskal-pa) байгуулаад лам нар Дүйнхор (төв. dus-'khor)-ын гүн ухааныг нягт судалж эхэлсэн. II богдын байгуулсан жүдийн хурал Бадма ёга (төв. pad-ma yo-ga) нэртэй болсон. 1807 онд Хүрээний хойт зүгт Шаддүвлин (төв. bshad-sgrub gling) дааны газрыг байгуулсан. 1809 онд Төвдийн Бэрэйвэн хийдийн Лосаллин (төв. blo-gsal-gling) дацангийн маягаар (Ванчин игчаа) Гандангийн дэнжид хүрээний хоёрдугаар “Цанид” буюу чойр (төв. chos-grwa)-ын хурал байгуулагдсан.

Позднеевийн бичсэнээр (1971, 45-46.) IV богдын үед Хүрээ бол шашны төвөөс гадна засаг захиргаа, хятадын худалдааны томоохон төв болсон байжээ.

Мөн Их хүрээ нэрээ өөрчлөн Да хүрээ болсон байна.

V богд Лувсанцүлтимжигмэддамбийжалцан (төв. blo-bzang tshul-khrims 'jigs-med bstan-pa'i rgyal-mtshan, 1815-1841) (“Алтан дэвтэр” 117г-120г) 1837 онд Гандангийн дэнжид байсан 2 цанид дацанд Дашчойнпэл (төв. bkra-shis chos-'phel) ба Гунгаачойлин (төв. kun-dga'

chos-gling) нэрүүдийг өгсөн. 1839 онд хүрээ Толгойт тийшээгээ нүүж, шар орд нь Гандангийн дэнжид байж, Богдын ордон болон Гандантэгчэнлин нэртэй Цогчин дуган баригдсан. 1840 онд Туул голын эрэгт Цагаан сүм буюу Гунгаадэжидлин ба Пандэлин сүмүүдийг байгуулсан.

VI богд (1843-1848) бага байхдаа таалал төгссөн.

VII богд Агваанчойживанчүгпринлэйжамц (төв. ngag-dbang chos-kyi dbang-phyug 'phrin-las rgya-mtsho, 1850-1868). 1855 онд Хүрээ Сэлбэ голын эрэгт буцаж ирснээр дахин нүүлгүй суурьшсан байна. Хүрээний аймгуудын тоо VII богд болон VIII богдын үест 30 болжээ. Шинээр нэмэгдсэн 8 аймаг нь:

Махамаяа (санс. Mahāmāyā), Дондовлин (төв. don-grub gling), Тойсамлин (төв. thos-bsam gling), Намдоллин (төв. nam-grol gling), Жамъяансүн (төв. 'jam-dbyangs bsrung/gsung ?), Чойнхорлин (төв. chos-'khor gling), Дашдандарлин (төв. bkra-shis bstan-dar gling), Эх дагина (санс. pākīnī) (1903 оны сүүлчээр байгуулсан) зэрэг аймгуудын тус тус байгуулжээ.

VIII богд Агваанлуванчойжинямданзанванчүг (төв. ngag-dbang blo-bzang chos-kyi nyi-ma bstan-'dzin dbang-phyug, 1870-1924) Богд хааны ногоон сүм, өвлийн ордон ба Чойжин ламын (төв. chos-skyong bla-ma) сүмийг барьсан. 1911 онд тусгаар тогтносоноор Богд хаант Монгол улсыг зарлан тунхагласан. Нийслэлийн нэрийг ч мөн сольж Да хүрээг Нийслэл хүрээ хэмээн нэрлэх болжээ. VIII богдыг хаан ширээнд залсан. Богд хаан (1911-1921)-ы үед 1911 онд Гандангийн дэнжид 3 дахь чойрын дацан Идгаачойнзинлин (төв. yid-dga' chos-'dzin gling), ба Мигжид Жанрайсэг дацан (төв. mig-'byed spyan-ras-gzigs)-гууд тус тус байгуулагдсан байна. Тухайн үед Хүрээний түмэн гэлэнгийн хайлин (төв. khas-len), 30 аймаг, 10 дацан, Шар ордонгийн Цам бүжиг (төв. 'chams), Зүүн хүрээний Майдар эргэх, Бат оршил өргөх буюу даншиг (төв. brtan-bzhugs) наадмаараа алдартай байжээ. Сүм дацангуудын жасууд тухайн үед мал сүргээр баян байв.

Нийслэл хүрээний хороо, хорооллуудад байсан сүм, дуганууд

Жүгдэрийн зурсан зургийн дагуу 1913 онд Нийслэл хүрээ хороо, хорооллууд нь:

Лам нарын суудаг байсан Зүүн хүрээ (1.), болон Гандан (2.); Харчуудын хороонууд (3.): Баруун өмнөд болон Зүүн өмнөд хороо, Зүүн харчууд болон Их шавь; Чойжин ламын сүм (4.), Богд хааны орд харш Туул голын эрэг дэхь (5.); Орос консулын дэнж (6.); Хятад худалдааны хот буюу Маймаачэн (7.), Хятад дамнуурчингуудын хэсэг: Зүүн болон Баруун дамнуурчин (8.); Хотын захын газруудад (9.) хуваагддаг байжээ.

1. Зүүн хүрээ

Зүүн хүрээнд (одоогийн Сүхбаатар дүүрэг. Зүүн хүрээний төв хэсэг нь Хүүхдийн урлан бүтээх төв ба МУИС-ийн IV байрын орчим) зөвхөн лам нар

амьдардаг байв. Зүүн хүрээний төв хэсэгт Өндөр гэгээн Занабазарын санаачилсан хэлбэрийн дагуу баригдсан Рэбогэжай Ганданшаддүвлин буюу Бат цагаан цогчин дуган болон Богдын Шар ордон байжээ. Цогчин дуган өдөр бүр Цогчин уншлагтай байлаа. Дашцэрэн ламын ярьсанаар Цогчин дуганы сарын дүйцэн өдрүүд шинийн 8, 15, билгийн тооллын 30-нд тус тус байжээ. Бусад хурлууд нь жандаг (төв. sbyin-bdag)-уудаас хамаардаг байсан байна.

О.Пүрэв номондоо (2004, 9-10.) Шар ордонгийн шар хашаан дотор байсан сүм дугануудыг тодорхойлохдоо:

Гурван давхар алтан дэвэртэй Дэчингалавын (төв. bde-chen bskal-pa), түүний зүүн талд Ригсүмгомбын сүм (төв. rigs-gsum mgon-po), түүний хажууд III богдын зарлигаар бүтээсэн Доржповран (төв. rdo-rje rho-brang), ба Очирдарийн сүм (төв. rdo-rje 'dzin-pa) байснаас гадна гэр тугдам олон байжээ. Хашаан дотор Түнлхагийн хурал (төв. 'khrungs lha) бол Богдыг урт наслахын тухайдал, Намсрайн хурал (төв. nam-thos-sras) бол Богдын сан хөмрөг арвижиж байхын тухайд хурдаг байсан байна.


Цогчин дуганы ард 1834 онд барьсан Майдарын сүм (Сэрээтэр, 1999, 69.) ирээдүйн бурхны 50 тохой (16m) өндөр шүтээнийг дотор нь залаастай. Цогчин дуганы баруун талд Манба дацан (анх байгуулсан: 1760 он) ба Өндөр гэгээний бүтээсэн Манал (төв. sman-bla) бурхныг залсан Ноён шүтээний сүм оршиж байв. Үүний ар талд Дарь эхийн сүм байжээ.

О.Пүрэв (2004, 19.) Цогчин дуганы ард Ганжуурын дуган (төв. bka-'gyur-gyi 'du-khang), Гүрмийн дуган (төв. sku-rim-gyi 'du-khang), Солгийн дуган (төв. gsol-gyi (?) 'du-khang) бас Хойд өргөө байсан хэмээн тэмдэглэсэн байна. Хойд өргөө бол Их хүрээний шашны захиргааны шийдэх газар байсан. Сэрээтэр (1999, 55.), Дариймаагийн (2003, 18.) бичсэнээр Их хүрээний шашны асуудлуудыг Богдын томилсон Их хүрээний 7 цорж (төв. chos-rje) шийдсэн (хамба номун хан, дэд хамба, 5 цорж бүгд гэлэн сахилтай (төв. dge-slong) аграмба (төв. sngags-tams-pa) нар байжээ. Цогчин дуганы 4 гэсгүй/гэвгүй (төв. dge-bskos) ба 4 унзад/умзад (төв. dbu-mdzad) нар нэг төрлийн шийдвэр гаргадаг байсан.

Шар ордоны зүүн талд Зурхайн дацан (төв. rtsis-pa grwa-tshang, анх 1789 онд байгуулсан), Жүд дацан (төв. rgyud-kyi grwa-tshang, анх 1759 онд байгуулсан), тэдгээрийн өмнө талд Дуу тасрахгүй хурал байжээ.

Гэр тугдмуудаас хамгийн алдартай нь Шар ордоны баруун талд байсан Автай сайн ханы өргөө буюу Баруун өргөө Монгол улсын голомтыг хамгаалж байлаа.

• Зүүн хүрээний дээр дурдсан төв хэсгийг 30 аймаг (хүрээ дэг, төв. sgrig) тойрон хүрээлсэн байлаа. Аймгууд эрхэлж байгаа аж ахуй, хутагт хувилгаад, гарал үүслийн дагуу нэрлэгдэж байжээ. Аймгуудад хэдэн зуун лам нар өөр өөрсдийн аймгийн хуралд хурдаг байсан бөгөөд Гандангийн дацангуудад суралцдаг байв. Аймгуудын ихэнх нь Эх дагинын аймгийн хурлын дуган шиг гэр хэлбэрийн модон дуганууд байсан хэдий ч эсгий гэр,



- ШАЖИНИБЫТ
- 1 Их хурлын ордон (Цогчин дуган)
 - 2 Баруун дамиурчин
 - 3 Баруун өмнөд хороо
 - 4 Зүүн харчууд
 - 5 Зүүн дамиурчин
 - 6 Зүүн өмнөд хороо
 - 7 Чойжин ламын сүм
 - 8 Өмнийг тэтгэгч цагаан сүм (Дунжингарзавын сүм)
 - 9 Ерөнхий лам
 - 10 Хайстай ордон
 - 11 Өзний хутагт номын хурд (Дашчойнхорын хурд)
 - 12 Зөвлөн эгшгийн хийд (Мандширын хийд)
 - 13 Консулын дэнж
 - 14 Наймаа хот
 - 15 Эрдэний хийд (Норволнхуа)
 - 16 Торгон цэрэг
 - 17 Тус амгалангийн сүм
 - 18 Майдарын сүм
 - 19 Номлон бүтээлийн хийд (Шадвилн)
 - 20 Бун ервэлтийн сүм
 - 21 Шашныг бадруулагч хийд (Дамбадаржаа)
 - 22 Төгс багсалагт их хөлөн хийд (Гандангачилэн)
 - 23 Билигт хөгжүүлэн бадруулагч
 - 24 Шар Ордон
 - 25 Мэлимтгээрз болгоосон сүм
 - 26 Хотол багсалагт амгалан жэр-галангийн сүм

дөрвөлжин хэлбэрийн дуган ч бас байлаа. (Пүрэв, 2004, 19)

XIX зууны эцэст аймгууд нь их цэвэрхэн, нарийн гудмуудтай байжээ. (Позднеев 1971, 64). Хашаан дотор голдуу 2 гэр байх ба нэг гэр нь амьдрах, харин нөгөө гэр нь гал тогоо байрладаг байв. Арай баян лам нар зун суух модон байшин байдаг байжээ. Үүд нь зөвхөн урд зүгт харсан байна. Тоосгоор зөвхөн сүм дуган барихад л ашиглаж байжээ. Богд өглөө сүсэгтэн олонд адис өгдөг байсан

Зүүн хүрээнд суврага, ном барладаг бархан (төв. rag-khang) байдаг байлаа. Эргэн тойрон том том хүрдүүдийг гороолж (төв. skog) явдаг.

Дашцэрэн ламын ярьсанаар шөнийн цагт чавганц, хүүхдүүдээс гадна хүрээнд хар хүн хонох боломжгүй. Худалдаачид хүрээнд орох нь хорiotой байсан ч 1930 оноос дүрэм журам жаахан зөөлөрч дэлгүүр мухлагууд нээгдэж эхэлжээ.

1. Гандан

Гандан (төв. dga' ldan) буюу Баруун хүрээний дэнж нь суралцах, сахил санваараа сахидаг ариун газар байлаа. IV богдын үед Гандангийн дэнж дээр Дашчойнпэл ба Гунгаачойлин дацангууд, Дашчойнпэл дацангийн баруун талд гүрмийн Бадма ёга (төв. rad-ma yo-ga) дацан байсан. V богд Ганданд нүүж ирсэнээр түүний орд болон Гандантэгчэнлин хийдийн цогчин дуган 1838 онд баригдсан байна. Гунгаачойлин дацангийн баруун талд Ламрим дацанг 1844 онд барьсан. Чойрын 2 дацангийн ар талд 1910 онд Идгаачойнзинлин дацан, баруун талд нь 1911 онд барьсан Мигжид Жанрайсэг өндөр шүтээнтэй Жанрайсэг дацан.

XIII далай ламыг 1904-1905 оны хооронд ирэхэд Дидинповран (төв. bde stong pho-brang) баригдсан. Гандан V, VII, VIII богдуудын шарлуудыг хадгалж байна.

Дашцэрэн ламын ярьсанаар Ганданд зөвхөн лам нар ордог байжээ. 4 цагдаа журам сахиулина. О. Пүрэвийн номонд (2004, 18) Ганданд Зүүн хүрээний нэрүүдтэй адилхан 22 аймаг байсан. Харин Гончиг лам 30 байсан гэжээ. Зүүн хүрээнд багтаагүй лам нар Гандангийн аймгуудад ирдэг байжээ. Гандангийн ар талд суврагууд болон маш том хэмжээтэй Жаранхашарын суврага байсан (төв. bya-tung kha-shor). Дотроо хурал хурлаг байсан (Цагаан суврагын хурал).

2. Хороо

Дүгэрсүрэнгийн бичснээр (1999, 52.) хорооны харчууд бол Баруун өмнөд хороо болон Зүүн өмнөд хороонд суудаг. Зүүн хүрээнээс зүүн зүгт Зүүн харчууд ба Их шавьд амьдардаг. Хороонд хөдөөнөөс хааяа ирдэг тайж ноёдын сууц ч байдаг байжээ.

Баруун өмнөд хороонд (одоогийн Төв шуудан болон баруун дөрвөн замын хооронд) Түшээт хан, Сайн ноён хан, Засагт ханын хорооноос гадна төвд хороо, буриад хороо, дарьгангийн хороо гэж байсан. Дашцэрэн ламын ярьсанаар Богд хааны үед Гандангийн лам нар хороонд очиж худалдаачид, эмс охидтой холбогдох нь хорiotой байв. Хорооны сүм дугануудыг шашны захиргаа Нямапа ёсны (улаан малгайтан) лам нар гэрлэж болдог байсан

учраас тэдгээрийн сүм дуган хороонд байдаг байжээ. Үүнээс гадна эмс охид сонирхдог Зүүн хүрээ болон Гандангаас хөөгдсөн шарын урсгалын лам нар бас амьдардаг байжээ. Мөн шарын урсгалын сүм хийдүүд хороонд ч байсан. Дарь эхийн хурал, Доржзодвын хурал, Төвдийн хурал. Төвдийн хурлыг 1905 онд XIII далай ламтай цуг ирсэн лам нар хурал номоо нээсэн байна.

Дариймаагийн бичснээр (2003, 41.) бөө удган, мэргэ төлөгч хүмүүс ч байсан. Наргад Дагинын хурал ч энд байсан (Дамдин ламын хурал). Нямапа ёсны сүм хийдүүд нь нэг хашаан дотор зод ба лүйжин (төв. lus-sbuin) тавьдаг лам нарын Тантонжалбын дуган (зодын хурал) ба Жагармолумын хурал (Дэчинчойлин тавши сүнбрэлли, зодын хурал). Баруун өмнөд хороонд арилжаа худалдаа явагддаг байжээ. Мөн Бадарчингын дов хэмээх газарт ядуу гэр оронгүй, халдварт өвчтэй хүмүүс амьдардаг байв. (Позднеев, 1971, 73.)

Зүүн өмнөд хороонд (одоогийн Арслантай гүүрнээс баруун ба зүүн өмнөд хэсэг) Амбан ханы хороо гэдэг монгол, манж амбаны хороо байсан. Сүүлчийн манж амбан 1911 он хүртэл Хүрээнд суусан Сан-дуо, гэрийг нь Зүүн Сэлбийн эрэгт барьснаар Манж амбаны хурлын дуган үүсчээ. Цэ вангийн хороо болон Сэцэн ханы хороо, архив, гяндан энд байжээ. (Пүрэв 2004, 37.)

Зүүн харчууд (одоогийн Сэлбийн зүүн талд орших Сансар хорооллын хойт тал) Зүүн хүрээний зүүн хойт хэсэгт байв. 1883 онд байгуулагдсан энэ хороонд (Пүрэв 2004, 90.) Зүүн хүрээ, Хүрээний хойт хэсэгт орших Дашчойнхорлин ба Дамбадаржаа хийдийн лам нар, Богд, цол хэргэмтэй томоохон лам нар, тайж ноёдын хувцас малгай хийдэг гар урчууд суудаг байжээ.

Эдгээрээс зүүн өмнө (одоогийн Сэлбийн зүүн талд орших Сансар хорооллын өмнөд тал)

Богдын их шавиас ирсэн харчууд суух бөгөөд тусдаа Их шавийн хурал хурдаг байсан. Их шавийн өмнө хэсэгт XX зууны эхээр Америкийн пүүсүүд байснаас Американ дэнж хэмээн нэрлэх болжээ.

3. Чойжин Ламын сүмийн эргэн тойрон

Зүүн хүрээнээс өмнөд 1904-1908 оны хооронд барьсан Чойжин ламын сүм Лувсанхайдавын хурлын газар байлаа. Цам бүжиг 3 удаа гарсан. Агва дацан (төв. sngags-ra grwa-tshang). Чойжин ламын сүмийн зүүн талд нь Ёнзон хамбын сүм (төв. yongs-'dzin mkhan-po) бол VIII богд ба Лувсанхайдавын жавгүй ба ёнзон багш байсан Лувсанхаймчогын сүм байжээ. Чойжин ламын сүмийн хойт талд Ойдовын хурал ба Дагва зодчийн хурал байсан.¹¹

4. Туулын эрэг орчим

Өндөгийн сүргийн нутаг гэж байсан газарт (Пүрэв, 2004, 24.) Богдын төрөл садангуудын адуу, мал сүрэг байсан газрын дунд Богд хааны ногоон сүм, Богд хааны өвлийн ордон, амьтны хүрээлэн (Норовлин/Норовлинхай) байжээ. Ногоон ордонгоос зүүн тийшээ Эрдмийн далай буян чуулган сүм буюу Богдын сэрүүн ордон, Ногоон ордоноос баруун зүгт Цагаан сүм буюу Гунгаадэжидлин. Эдгээр ордоонуудад лам нар амьдардаг хэдий ч томоохон хурлуудыг хааяа хааяа хурдаг байв.

V богдын үед барьсан Пандэлин нь Богд хааны үед Туулын зүүн эрэгт байсан бөгөөд сүүлд Нархажидын сүм буюу Балданхажидлин нэртэй болжээ.

5. Орос консулын дэнж

Орос худалдаа наймаа дэлгэрсэнээр 1861 онд орос консулын газар нээгдсэн (одоогийн Кино үйлдвэрийн орчим). Оросууд эхлээд Консулын орчим суудаг байжээ. Консулын байшингийн зүүн талд 1869-1870 онд барьсан үнэн алдартаны сүм, Хутагт Тройцийн сүм байгуулагдсан.

6. Маймаачэн, хятад худалдаачдын газар

Манжийн хаанаас хятадууд Монголд ирж худалдаа наймаа хийх ба өр зээл тавихыг хориглосон атал улам олноороо ирцгээж байв (Rupen: 1957, 162-164). 1778 онд IV богд хятад худалдаачдыг одоогийн Амгаланд (Ботаник) нүүлгэснээр Маймаачэн (Маймаа хот, Наймаа хот, хят. маймайченг) хотын суурь тавигдсан байна.

Хотын хашаан дотор зөвхөн хятадууд, хашааны гадна монголчууд, эрлийзүүд амьдарч байжээ. Хятад сүм дуганууд 1920-оод он хүртэл үйл ажиллагаагаа явуулсан.

Позднеев хятадын Маймаачэнгийн пүүсүүдийн (пүүс, хят. пу зи) тухай дэлгэрэнгүй бичсэн (1971, 77-89.). Хятад хот монгол маягын хотоос эрс ялгаатай байсан.

XX зууны эхээр Амгаланд 14 сүм дуган байжээ. 8 хятад, 6 монгол сүм дуган байв. 7 хятад сүм нь Маймаачэнгийн хашаан дотор байсан хятад лам нар (хуушаан, хят. he shang) буюу хөх малгайтан лам нар хурал хурдаг байлаа. Маймаачэнгийн хойт хэсгийн төвд Гэсэр сүм байсан.

О.Пүрэвийн бичснээр (2004, 102.) бусад хятад сүмүүд зүүн өмнөд хороололд байсан:

Зүүн өмнөх буланд Одон сүм, дэргэд нь Күнзийн сүм буюу Күнз богдын сүм, түүний баруун талд Лалын сүм буюу Цагаан малгайтын сүм. Энэ сүмээс хойш одоо ч байгаа Дарь эхийн сүм. Түүний баруун талд хятадын Эрлэг хааны сүм ба Мужааны буюу Урчуудын сүм байжээ.

Хашааны гадна О.Пүрэвийн ярьснаар хойно буй хятадын оршуулгын газрын тэнд мөн Эрлэг номун хааны сүм байсан байна.

Монгол сүм дуганууд хэрмийн гадна Баруун хороо болон Зүүн хороонд байжээ. О.Пүрэвийн бичснээр (2004, 104-105.) Чойнхорлин сүм, Улааны ёсны зодч нарын хурал, үүний зүүн талд Дашсамданлин дацан буюу Эрлийзийн сүм байсан. Түүний зүүн талд Дэжидийн хурал хэмээх том гэр хэлбэртэй дуган байжээ. Ямпайгаас зүүн өмнө зүгт Дагданлин хурал байжээ. Ө.Сэрээтэр (1999, 82.)-ийн бодлоор тус 4 аймгийн (Чойнхорлин, Пунцоглин, Дэжидлин, Дагданлин) лам нар тус тус хурал хурдаг байжээ (40-90 лам). Дашсамданлин дацан нь Хүрээний 10 дацангийн нэг байв.

1920-оод оны үед хятадуудыг нүүснээс хойш Маймаачэнд оросын хуаран, мөн монголчууд суух болжээ. Дашсамданлин дацан 1937 он хүртэл хурал номоо хурж байсан. Бусад сүм дуган хэдэн он хүртэл хурал номоо хурж байсан тухай мэдээ баримт

тодорхойгүй байна.

7. Дамнуурчин/Дамнуургачин

1877 онд Маймаачэн болон Зүүн хүрээний хооронд, XX зууны эхээр Зүүн хүрээ ба Гандангийн хооронд хятад пүүсүүд нээгдэж эхэлсэн. Хятад худалдаачид бараагаа дамнуураар авчирдаг байснаас Зүүн дамнуурчин, Баруун дамнуурчин хэмээн нэр үүсчээ.

Зүүн дамнуурчин хороо (Сэлбийн зүүн эрэгт, Сансар хороолол) XX зууны эхээр Зүүн хүрээний зүүн талд үүсчээ (Пүрэв, 2004, 91., 2004, 66.). Монголчууд ногоо тарихаас гадна тэнд монгол, хятад худалдаачид худалдаа наймаа эрхэлдэг байжээ. Манжийн хуаран шинхуа (хят. sien khua) өмнө талд нь байрлаж байсан.

Баруун дамнуурчин (Тэнгис кино театр орчим) нь хятад худалдаа наймааны нэг хэсэг байлаа. О.Пүрэвийн бичснээр (2004, 82.) 1920-оод оны үед Маймаачэнгээс олон пүүс нүүн иржээ. Үүний хамт 1927 онд Гэсэр сүм нүүж ирсэн. 2 хүрээний хооронд Баруун дамнуурчны өмнө хэсэг Нийслэл хүрээний зах болдог байжээ (Позднеев, 1971, 64-73.). Хятад, орос, монгол худалдаачид холилдсон их хөлийн газар байв.

8. Хүрээний захад байсан хийд, сүм дуганууд

Чингэлтэй ууланд Их шавийн 3 томоохон хийд байсан. Нэг нь 4 дацантай олон сүм дугантай, 12 аймагтай Дамбадаржаа хийд. Нөгөө нь Цам бүжигтэй Дашчойнхорлин хийд. 3 дахь нь 16 гэлэнтэй, 4 гэцэлтэй Шаддүвлин хийд хэмээх даяны газар.

Богд хан уулын оргилд Богдын хийд (дуган) буюу Цэцээ гүний хурал жилд нэг удаа Богд хан уулын лус савдагт Монгол улсын сүлд хийморийг сэргээхийн тухайд даатгаж тахидаг байжээ. Уг уулыг тахихаар лам нар хүрээний Дүнжингаравын сүмээс гардаг байв.

Хүрээний захад тэр хавийн хүмүүс мөргөдөг мөргөлийн сүмүүд буюу лус савдагуудыг тахидаг сүмүүд байсан нь:

Баянзүрхийн дуган, Зүүн салааны хурал, Баруун салааны хурал, одоогийн Дарь эхийн рашаан дахь Лүмбүмгарав ба эмч ламын Санзайдоржийн хурал (Санзайн уулын хийд).

Нийслэл хүрээнээс үлдсэн сүм дуганууд

Их хэлмэгдүүлэлтийн үед мяндаг тушаалтай лам нарын ихэнхийг цаазлах юм уу эсвэл яллаж байсан. Мяндаг тушаалгүй лам нар нь хөдөө гарч малчин болох, цэрэгт татагдах, зарим нэг нь сургуульд суралцах болжээ. Хүрээний лам нарын зарим нь артельд ажил хийх болсон (гутлын артель, модны артель гэх мэт). Сүм хийдүүдийн хамгийн үнэтэй алт, мөнгө, зэс, гууль зэрэг эрдэнээр хийж чимэглэсэн баримал, шүтээнүүдийг ЗХУ авч явсан. Зарим нэгээр нь янз бүрийн зүйлд ашигласан байна. Үлдсэн хэсгүүдээс зарим нэгийг Гандан болон хотын бусад музейнүүдээс үзэж болно.

1938 онд Улаанбаатар хотын сүм хийдүүдийн ихэнхийг шатаах, эсвэл нурааж буулгасан. Үлдсэн зарим нь цэргийн хуаран, эмнэлэг, эмийн сан, агуулах, үйлдвэр, цирк, архив, музей гэх мэтээр ашигласан. Хүрээ, хороонд байсан хуучин гэр байшингууд үлдэж хоцорсонгүй.



Хуучин хүрээний дээр дүрдсэн 51 шашны түүхэн газраас хуучин хэвээр нэг ч сүм дуган үлдээгүй. 11 газар одоо байгаагаас өөр өөр зориулалтаар ашиглаж байна. 40 газарт ямар ч байсан гэх туйр үлдсэнгүй. Үүнээс гадна зарим хийдүүдийг хаана байсанг тогтоох боломжгүй болсон.

1. Зүүн хүрээ:

• Номын их хүрээ, Рибогэжай Ганданшаддүвлин (төв. *ri-bo dge-rgyas dga'-ldan bshad-sgrub gling*, R-910): Цогчин дуган (төв. *tshogs chen 'du-khang*) гэх мэт 15 орчим сүм дуганаас нэг ч үлдсэнгүй (N 47°55.583', E 106°55.030').

• Шар Ордон Дэчингалавын хурал (Дүйнхор дацан, төв. *bde chen bskal-pa, dus-'khor grwa-tshang*, R-925) гэх мэтээс огт үлдээгүй. (N 47°55.559', E 106°55.063'.) Дэчингалавыг 1994 онд Ганданд дахин барьсан.

• Зүүн хүрээний (NR-942) 30 аймгийн дугануудаас гурван дуган үлдсэн. Цирк байсан Эх дагинын аймгийн хурал (R-926, N 47°55.609', E 106°55.177') одоо циркийн сургууль, циркийн агуулах байсан Вангайн аймаг, Эрхэм тойны аймгийн дуганууд 1990 оноос Зүүн хүрээ Дашчойлин хийдийн Цогчин дуган, Сахиусны дуган. Харин бусад 27 аймгийн дуганууд үлдээгүй.

2. Гандан

• Гандантэгчэнлин (төв. *dga'-ldan theg chen gling*, R-912) Цогчин дуган малын хашаа болсон. V болон VII богдын шарилын сүм орос цэргийн хуаран болсны дараа 1944 онд Ганданг дахин нээхэд 7 лам анх ахин хурлаа хурж эхэлсэн. VIII богдын шарилын сүм бол одоогийн Гандангийн номын сан. Дидонповран (төв. *bde stong pho-brang*) одоо хурлаа хурж байна. (N 47°55.279', E 106°53.773')

• Гандангийн 5 дацанг 1938 онд шатаасан боловч 1990 оноос хойш 3 чойрын дацанг дахин сэргээн барьсан. Мигжид Жанрайсэг сүмийг (Жанрайсэг дацан, төв. *mig-'byed spryan-ras gzigs-kyi grwa-tshang*, R-913) нураахаасаа хүмүүс айж үлдээсэн. 1940-өөд оноос архив болгон ашиглаж байсан. Жанрайсэг бурхныг 1996 онд дахин бүтээж аравнайлсан. (N 47°55.374', E 106°53.698'). Цагаан суврагын хурал (Жаранхашарын суврага, Жаранхашарын сүм, төв. *bu-a-rung kha-shor*, NR-960) одоогийн зурагтын антен байгаа газар. (≈N 47°55.700', E 106°53.295')

3. Харчуудын хорооны сүм хийдүүдээс нэгэн ч үлдээгүй

Баруун өмнөд хороо

• Нартад Дагинын хурал (Дамдин ламын хурал, Нартад дагнангийн хурал, R-916) (≈N 47°54.852', E 106°54.485')

• Төвдийн хурал (Унзай ламын хурал, R-918) (≈N 47°55.025', E 106°54.148')

• Тантонжалбын хурал (зодын хурал, төв. *thang-stong rgyal-po, gcod*, R-919) (N 47°54.836', E 106°54.140')

• Дарь эхийн хурал (төв. *sgrol-ma*, R-917) (≈N 47°54.799', E 106°53.783' буюу ≈ N 47°54.833', E 106°54.432')

• Доржзодвын хурал (төв. *rdo-rje gcod-pa*, NR-952) (Дарь эхийн хурлын ойрхон)

• Жагармолумын хурал (Дэчинчойлин тавши сүнбрэллин, зодын хурал, төв. *bde-chen chos-dbyings-thabs-shes zung-'brel gling*, NR-950) (N 47°54.836', E 106°54.140')

Зүүн өмнөд хороо:

• Манж амбаны хурлын дуган (NR-949) (≈N 47°54.881', E 106°55.936')

Их шавь:

• Их шавийн харчуудын хурал (Сайхан Гомбын сүм, төв. *mgon-po*, R-927) (≈N 47°55.423', E 106°56.367')

4. Чойжин Ламын сүмийн эргэн тойрон

• Чойжин ламын сүм (Өршөөлийг хөгжүүлэгч сүм, Зонхан, Зэпэллин сүм, Номыг тэтгэгч, Шашин сахигчийн ордон, төв. *chos-skyong bla-ma, brtse-'phel gling, gtsang-khang*, R-915). Сүм хийдүүдийг устгаж байх үед олон шүтээн, уран барималуудыг энд цуглуулж, 1942 онд музей болгосон. (N 47°54.904', E 106°55.102')

Эргэн тойрон байсан сүм хийдүүд үлдээгүй:

• Ёнзон хамбын сүм (төв. *yongs-'dzin mkhan-po*, NR-947) (N 47°54.875', E 106°55.154')

• Ойдовын хурал (Юутавын хурал (?) R-920) (≈N 47°54.854', E 106°54.563' буюу N 47°54.984', E 106°55.108')

• Дагва зодчийн хурал/сүм (төв. *gcod*, NR-951) (≈N 47°54.854', E 106°54.563' буюу N 47°54.984', E 106°55.108')

• Агва дацан (Аху дацан, Аваг дацан, төв. *sngags-pa grwa-tshang*, NR-953) (≈N 47°54.984', E 106°55.108')

5. Туул голын орд харшууд

• Богд хааны ногоон сүм (Богд хааны өвлийн ордон, Шаравпэлжээлин сүм, Эрдэм итгэмжит билгийг хөгжүүлэн бадруулагч сүм, Дээд сүм, Голын ногоон сүм, төв. *shes-rab dpal rgyas gling*, R-911). Одоо Богд хааны ордон музей. (N 47°53.867', E 106°54.417')


• Хайстай лавран (Эрдмийн далай буян чуулган сүм, Богд хааны сэрүүн орд, Хайстай ордон, Хайлаастын сүм ордон (?), Хашаатай лавран) (R-921) таван байшин үлдсэн. Нэг нь 1996 оноос Нийслэлийн Цагдаагийн газрын хүүхдийн халамж үйлчилгээний төв, нөгөө дөрөв нь хоосон буюу орон сууц. (N 47°53.662', E 106°54.821')

Үлдээгүй орд цэцэрлэг:

• Цагаан сүм (Гунгаадэжидлин) (Доод сүм, Туулын цагаан сүм, Хотол баясгалант амгалан жаргалангийн сүм, Өвгөн цагаан сүм, Хутагтын цагаан сүм, төв. kun-dga' bde-skyid gling, R-922) ($\approx N 47^{\circ}55.570'$, $E 106^{\circ}52.696'$)

• Нарохажидын сүм (Нархажидын сүм, Пандэлин, Тус амгалангийн сүм, Балданхажидлин, төв. na-ro mkha'-spyod, phan-bde gling, dpal-ldan mkha'-spyod gling, R-923) ($\approx N 47^{\circ}53.268'$, $E 106^{\circ}54.584'$)

• Норовлин (Норовлинхай, Эрдэнийн сүм, төв. nor-bu gling-ka, NR-943) ($N 47^{\circ} 53.776'$, $E 106^{\circ}54.542'$)



6. Орос Консулын дэнж

• Хутагт Тройцийн сүм (Свято-Тройцийн сүм, Гэгээн Гурвалын сүм, Үнэн алдартны сүм, R-928), сүмийн үлдсэн хэсэг одоо internet cafe байна. Шинээр Үнэн алдартны 3 том байшин хуучин газрын ойрхон баригдсан байна. ($N 47^{\circ}55.000'$, $E 106^{\circ}57.573'$)

7. Маймаачэн (Маймайченг, Маймаа хот, Наймаа хот)

• Дарь Эхийн сүм (төв. sgröl-ma, R-931), хуучин хятад байшингууд одоо Дулмалин хийд (төв. sgröl-ma gling bt-sun dgon) буюу Дарь эх хийд гэдэг эмэгтэй лам нарын хурал хурдаг хийд. ($N 47^{\circ}54.375'$, $E 106^{\circ}59.955'$)

Бусад үлдээгүй сүм дуганууд: (GPS-ээр тогтоох боломжгүй)

• Эрлэг номун хааны сүм (R-929)

• Амгалангийн Гэсэр сүм (Гуан-ди шүтээн, R-930)

• Урчуудын сүм (Мужааны сүм, R-932)

• Күнзийн сүм (Күнз богдын сүм, R-933)

• Цагаан малгайтын сүм (Лалын сүм, төв. kla-klo, R-934)

• Дашсамданлин хурал/дацан (Эрлийзийн сүм, Өлзий даяны сүм, Сандлин дацан (төв. bkra-shis bsam gtan gling grwa-tshang, R-935)

• Одон сүм (NR-945)

• Эрлэг номун хааны сүм 2 (Эрлэг хааны хойд сүм, NR-948)

• Чойнхорлин сүм (төв. chos-'khor gling, NR-955)

• Дэжидлин сүм (төв. bde-skyid gling, NR-956)

• Дагданлин сүм (төв. rtag-brtan gling, NR-958)

• Пунцоглин сүм (төв. phun-tshogs gling, NR-957)

• Улааны шашны зодч нарын хурал (Маймаачэн) (төв. gcod, NR-959)

8. Дамнуурчин/Дамнуургачин

• Баруун Гэсэр сүм (Гуан-ди шүтээн, R-914): хятад сүм нь жүжигчдийн орон сууц байсан. Дараа нь архив болсон. Түүний дараа Гандангийн Манба дацан. Зурхайн дацан. Харин одоо Бадма ёга дацан ба шашны дунд сургууль үйл ажиллагаагаа явуулж, заримдаа ардын эм тангаар өвчтөнд үйлчилж байна. ($N 47^{\circ}55.389'$, $E 106^{\circ}53.953'$)

9. Хүрээний захад байсан сүм хийдүүд

• Дамбадаржаагийн хийд (Дамбадаржаа, Дамбадаржаалин, Шашныг бадруулагч хийд, төв. bstan-pa dar-rgyas gling, R-939), зарим дуган үлдсэн. Олзны япон цэргийн эмнэлэг, дараа нь Сүрьеэгийн эмнэлэг. Түүний дараа Өндөр настны сувлал байсан. 1990 онд хуучин Сэцэн тойны аймгийн дуганыг сэргээж хурал номыг дахин эхлүүлсэн. Үлдсэн дугануудын заримыг сэргээн засварласан ($N 47^{\circ}58.953'$, $E 106^{\circ}56.263'$)

Үлдээгүй сүм хийдүүд:

• Дашчойнхорлин хийд (Буян ерөөлт(ийн) сүм, төв. bkra-shis chos-'khor gling) (R-936) ($N 48^{\circ}00.477'$, $E 106^{\circ}56.194'$). Нэг багана, хэдхэн тоосго үлдсэн.

• Шаддүвлин хийд (Шаддүвлин, Шаддүв гээл жанчүвлин, Их шавийн нямба даяаны Шаддүвлингийн хүрээ, Номлол бүтээл баян арвидах Бодь тив (төв. bshad sgrub gling, bshad-sgrub dge 'phel byang-chub gling, R-937) ($N 48^{\circ}00.843'$, $106^{\circ}54.195'$, бясалгалын сүм: $N 48^{\circ} 01, 071'$, $E 106^{\circ} 52, 863'$). Байшингийн суурь хадгалагдаж байна. Бясалгалын газарт шинээр барьсан бясалгалын байшингууд бий.

• Дүнжингарвын сүм (Дүнжонгарвын сүм, төв. dung-skyong dkar-po, R-924) ($N 47^{\circ} 54.830'$, $E 106^{\circ} 55.344'$)

• Богдын хийд (дуган) (Цэцээ гүний хурал, R-938) ($N 47^{\circ}48.492'$, $E 107^{\circ}00.164'$). Байшингийн суурин дээр төрийн овоог босгосон.

• Рашааны хурал (Лусын жалваа, Лусын жалвуу, Лүмбүмгарав, Лусын сүм, Ловон Жалбын сүм (?), төв. klu-rgyal, klu'i rgyal-po, klu-'bum dkar-po, NR-944). Рашаан одоо ч бий.

• Зүүн салааны хурал (R-940) ($\approx N 47^{\circ}59.664'$, $E 106^{\circ}53.157'$)

• Баянзүрхийн дуган (Хөлний модчны сүм, R-941) ($\approx N 47^{\circ} 53.309'$, $E 107^{\circ}04.097'$)

• Баруун салааны хурал (NR-946) ($\approx N 47^{\circ}58.190'$, $E 106^{\circ}48.491'$)

• Сайзайн уулын хийд (Сайзайдоржийн хурал) (NR-954) (одоогийн Сайзай уул)

1944 онд Ганданг дахин нээсэн боловч 1990 он хүртэл Монгол улс дахь цорын ганц хийд байсан. 1990 оноос хойш сүм хийдүүдийг дахин сэргээж, шинээр барьж байгуулснаар одоо 36 гаруй хийдүүд хурал номоо хурж байна.¹²

Ном зүй:

• Дариймаа, Г., Дурсагдахын буянтай бурхан зураач, УБ, 2003

• Дүгэрсүрэн, Л., Улаанбаатар хотын түүхээс (2 дахь хэвлэл), УБ, 1999

• Жүгдэр, Yeke kyiyeu 1913 он (зураг)

• Lokesh Chandra (ed.), The Golden Annals of Lamaism.

Hor chos-'byung of Blo-bzang rta-mgrin. 'dzam-gling byang phyogs chen-po hor-gyi rgyal-khams-kyi rtags-pa brjod-pa'i bstan-bcos chen-po dpyod-ldan mgu byed ngo-mtshar gser-gyi deb-ther zhes-bya-ba bzhugs-so Śāta-Piṭaka Series. Vol. 34. New Delhi, 1964

• Pozdneyev, A. M., Mongolia and the Mongols, edited by Krueger, J. R., translated by Shaw, J. R. and Plank, D., Bloomington, Indiana University 1971

• Пүрэв, О., Монголын улс төрийн төв, УБ, 1994

• Пүрэв, О., Улаанбаатар 360. УБ, 1999

• Пүрэв, О., Монгол төрийн голомт, УБ, 2004

• Ринчен, Б., Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас. УБ, 1979

• Rupen, R. A. "The City of Urga in the Manchu Period", Studia Altaica, Festschrift für Nicholas Poppe, Wiesbaden, 157-169., 1957

• Сэрээтэр, Ө., Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтэцийн товч 1651-1938. УБ, 1999

• Улаанбаатар. Хотын атлас. Улсын геодези, зураг зүйн газар. УБ, 1990

• www.archives.gov.mn/index.php?option=com_content&task=view&id=567&Itemid=302&lang=mn

• www.mongoliantemples.net/en

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Уг өгүүлэг нь 2005-2006 онд монгол судлаач Majer Zsuzsa, Teleki Krisztina нарын хамтарсан судалгааны товч тайлан. Судалгааны зорилго нь Улаанбаатарын сүм, дугануудын байсан газруудыг тогтоох, өнөө үед ямар байгаа талаар тэмдэглэх, судлах явдал байсан. Тус судалгааны дэлгэрэнгүй нь <http://www.mongoliantemples.net/en/> цахим хуудсан дээр гарсан. Teleki Krisztina-гийн судалгааг Унгар улсын "Magyar B-lami Ectvcs Цзштүнднј", Majer Zsuzsa-гийн судалгааг "Magyar Цзштүнднј Bizottsbg", "Tan Karuja Buddhista Alarntvbnу" эдгээр албан газрууд ивээн тэтгэсэн.

2. Ринчен, Б., Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас. УБ, 1979. Дараа үзэх Майдар, Д., Монголын хот тосгоны гурван зураг; УБ, 1970; Цэдэндамба С.- Лхагва Л. - Сонинбаяр Ш. - Лувсанвандан Е. - Отгонбаатар Р. - Амгалан Н., Монголын сүм хийдийн түүхэн товчоон, УБ, 2009; Teleki Krisztina, Bogdiin Khree: Monasteries and Temples of the Mongolian Capital, PhD dissertation, 2009

3. Forbóth, L, A megujhodott Mongolia, Franklin, A Magyar Fildrajzi Tbrsasbg Kцnyvtbra, Budapest, 1934; Geleta J., The New Mongolia, by Ladislau Forbath, as related by Joseph Geleta; translated from the Hungarian by Lawrence Wolfe, London, Toronto, W. Heinemann Ltd., 1936; Шепегилников, Н. М., Архитектура Монголий, Москва 1960; Майдар, Д., Монголын архитектур ба хот байгуулалт, УБ, 1972; Halen, H, Memoria Saecularis Sakari Palsi. Aufzeichnungen von einer Forschungsreise nach der Nordlichen Mongolei im Jahre 1909 nebst Bibliographien, Helsinki, 1982; Цүлтэм, Н., Mongyol-un uran barilа, УБ, 1988

4. Позднеев, А. М., Монголия и Монголий. Т. 1-2. Санкт-Петербург, 1896, 1898; Pozdneyev, A. M., Mongolia and the Mongols, edited by Krueger, J. R.,

translated by Shaw, J. R. and Plank, D., Bloomington, Indiana University 1971

5. Bira, Sh., The History of Mongolia. (Tibetan text in Roman transcription. Dharmāṭala Dam chos rgya-mtsho, Śāta-Piṭaka Series. Vol. 235. New Delhi, 1977;

Гомбожав, С. (орчуулсан), Дармадала, Их Монголын оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч цагаан лянхуан эрхис хэмээх оршвой, УБ, 1995; Huth, G., Geschichte des Buddhismus in der Mongolei. Aus dem Tibetischen des 'Jig-med nam-mkha'. Karl J. Trübner. Strassburg 1892; Lokesh Chandra (ed.), The Golden Annals of Lamaism. Hor chos-'byung of Blo-bzang rta-mgrin. 'dzam-gling byang phyogs chen-po hor-gyi rgyal-khams-kyi rtags-pa brjod-pa'i bstan-bcos chen-po dpyod-ldan mgu byed ngo-mtshar gser-gyi deb-ther zhes-bya-ba bzhugs-so Śāta-Piṭaka Series. Vol. 34. New Delhi, 1964; Бүрнээ; Д. - Энхтөр, Д., Монголын Бурханы шашны түүхэн сурвалж. УБ, 2004

6. Позднеев, А. М., Монголская Летопись Эрдэнийн эрхис Материалы для истори халхи, Санкт-Петербург, 1882; Bawden, Ch. R., The Jebtsundamba khutukhtus of Urga. Text, Translation and Notes, Otto Harrassowitz, Wiesbaden, 1961

7. Пүрэвжав, С., Хувсгалын өмнөх Их хүрээ, УБ, 1961; Пүрэв, О., Монголын улс төрийн төв, УБ, 1994; Пүрэв, О., Монгол төрийн голомт, УБ, 2004; Сэрээтэр, Ө., Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтэцийн товч 1651-1938. УБ, 1999

8. Bawden, C. R., (transl.), Tales of an Old Lama, translated with notes by Bawden, C. R., The Institute of Buddhist Studies [Buddhica Britannica Series Continua VIII], Tring, U. K., 1997; Дамдинсүрэн, Ц., Өвгөн Жамбалын яриа, УБ, 1959; Дамдинсүрэн, Ц., Түүвэр зохиол, УБ, 1969; Наваан, Д., Өвгөн Дэндэвийн дурдатгал, УБ, 1961

9. www.mongoliantemples.net/en/; www.mongolianoral-history.org

10. http://www.archives.gov.mn/index.php?option=com_content&task=view&id=567&Itemid=302&lang=mn

11. Улааны ёсны хурал байсан бололтой. Яг байсан газрын талаар зөрүүтэй баримтууд байна

12. www.mongoliantemples.net/en

Зургийн тэмдэглэгээ

1. Жүгдэрийн зурсан зураг 1990 онд дахин Улаанбаатар хотод хэвлэгдсэн хуулбар дээр (Улаанбаатар. Хотын атлас. Улсын геодези, зураг зүйн газар. УБ, 1990) Ринченгийн тэмдэглэсэн (R-910-941) дугаарууд болон Ринченгийн атласт ороогүй (NR-942-960) дугаартай сүм хийдүүдийг нэмж тэмдэглэсэн болно.

2. Д. Дамдинсүрэнгийн (1909-1984) Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж байгаа "Наадам" (1960) зурган дээр Зүүн хүрээний төв хэсгийн дугануудын нэрийг бичиж тэмдэглэсэн.

3. Дэчингалва ба Ригсүмгомбын сүм (Кино Архив: K24020)